



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017-02-19 № 01/29

**ӨЛЗИЙТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫНСУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ П.АЛТАНТУЯА ТАНАА**

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,073,642.00 /Таван сая далан гурван мянга зургаан зуун дөчин хоёр/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Багш ажилчдыг эрүүл мэндийн урьдчилсан шинжилгээнд хамрагдахад зориулж үндсэн цалингаас 960,000.00 / Есөн зуун жаран мянга / төгрөгийн хөнгөлөлт олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/ мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/заасныг тус тус зөрчсөн.
2. Багш, ажилчдын ажлыг үнэлэхдээ шалгуур үзүүлэлтийг харгалзалгүйгээр нийт 3,913,642.00 / Гурван сая есөн зуун арван гурван мянга зургаан зуун дөчин хоёр / төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон. Энэ нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 2010 оны 8 сарын 16-ны өдрийн 362/112/183 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6-д /Багш, ажилтны ур чадварыг үнэлэхдээ дараах тусгай шалгуур үзүүлэлтийг баримтлана/ заасныг зөрчсөн.
3. Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар 200,000.00 / Хоёр зуун мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсан. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх / заасныг тус тус зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/, 4.1.7-д /Хууль тогтоомж

зөрчсөн , алдаа зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх;
2. Зохих журмын дагуу шалгуур үзүүлэлтийг хангасан ажилчдад ур чадварын нэмэгдлийг олгож, төсвийн хэмнэлтийн горим мөрдөж ажиллах
3. Аливаа шийдвэргүйгээр ажил гүйлгээг бүртгэлд тусгахгүй байх;
4. Санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах;
5. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 03 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхийг Өлзийт сумын Ерөнхий боловсролын захирал /П.Алтантуяа/, нягтлан бодогч /Г.Мөнхбаясгалан/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

ШИНЖЭЭЧ



С.ЖАЛБАА

ДАРГА



П.АЛТАНТУЯА

НЯГТЛАН БОДОГЧ



Г.МӨНХБАЯСГАЛАН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.